

Ялалтын 70 жил - Хамтын ажиллагаа



Тэмдэглэлт ойн арга хэмжээний омнох одор Горний Алтайн Улсын их сургууль дээр 1939 оны Халхын голын байлдааны ялалтын 75 жилийн ой, 1941-1945 оны агуу их эх орны дайнд немцийн фашистуудыг бут цохиход Монголын ард түмний үзүүлсэн тусламжийн тухай сэдвийг голчилсон олон улсын эрдэм шинжилгээний хоёр дахь удаагийн хуралдаан болов.

Хуралдаанд Монгол улсын Үндэсний их сургуулийн профессор Наваанзоч Х.Цэдэв, нэрт тvvхч Дашдоржийн Монхбат, Монгол улсын “Ховдын толь” сонины еронхий редактор Гонгоржавын Тормонх нар хврэлцэн ирж оролцлоо. Мон эл хуралдаанд Горний Алтайн улсын их сургуулийн аспирантууд, Монголын үндэсний их сургуулийн ахмад багш Владислав Терентьев. Хятад улсын Шинжааны их сургуулийн хятад хэлний багш Ян Цзяо, тvvхийн шинжлэх ухааны доктор Николай Модоров, Горний Алтай хотын нэгдvгээр дунд сургуулийн тvvхийн багш Игорь Николаев нарын судлаач эрдэмтэд тус тусын илтгэл мэдээллийг бэлтгэж хэлэлцvүлсэн.

Хуралдааныг Горно-Алтайн их сургуулийн эрдэм шинжилгээ, инновацийн асуудал хариуцсан дэд захирал Юрий Табакаев нээж vг хэлэв. Тэр хэлсэн vгэндээ 1945 оны 5 сарын 9-нд болсон ялалтын баярыг Ойрат тур хотод /тухайн вед Горний Алтай хотыг ийнхvv нэрлэдэг байв/ хэрхэн тэмдэглэж байсныг дурсан vгvүлж, энэ нь Оросын иргэн бvрийн амьдралд тохиолдсон хамгийн чухал тэмдэглэлт вйл явдал болсон гэдгийг чухалчилан дурьдав. Дараа нь хуралдаанд оролцогчдад хандан Алтайн Бvгд Найрамдах

улсын хvндэт иргэн, тус улсын ахмад дайчдын зовлолийн дарга, ахмадуудын эрхийг хамгаалах хорооны дарга Борис Алушкин мэндчилгээ дэвшvүлсэн.

Тvүхч Дашдоржийн Монхбат илтгэлээ “Монголын улаан арми 1941-1945 оны агуу их эх орны дайнд” хэмээн нэрлэжээ. Тэрээр хэд хэдэн тоон баримтуудад судалгаа анализ хийсэн ба тvүний дvгнэлтээр Монгол орон даяар “Хувьсгалт Монгол” танкийн цувааг бvрдvүлж “Монгол ард” нисэх онгоцны эскадрилыг байгуулан Зовлолтийн улаан армид бэлэглэхийн зэрэгцээ Улаан армид туслах тусламжийн санд 65.0 сая тогрог, 100.0 мянган доллар, 300.0 килограмм алтыг хуримтлуулан илгээсэн байна. Тэрчлэн морин цэргийн анги нэгтгэлvүдэд 800.0 мянга гаруй агтыг бэлтгэж, тусламжаар нийлvүлсэн, Монгол хонь, тэмээний ноосыг боловсруулан, оёж, вйлдвэрлэсэн олон мянган шинелийг фронтод илгээсэн нь зовлолтийн цэрэг, офицер, генералуудын таван хvн тутамд нэг шинель ногдож байсан байна. Эдгээр тусламж нь буцалтгvй байснаараа хожим ямар ч vнэ толбор нэхээгvйгээрээ Америкийнхнаас ялгаатай гэсэн юм.

Д.Монхбат цааш нь тэмдэглэн хэлэхдээ “Гэсэн ч оноодор японы vзэл суртлын машинА ажилласаар Халхын голд болсон вйл явдал болон Монгол Зовлолтийн армийн ялалт, тvүнчлэн дэлхийн хоёр дугаар дайн, агуу их эх орны дайны тvүхэн ялалтын ач холбогдлыг бууруулах, бvдэгрvүлэн булзайруулах гэсэн хандлага нэлээд ажиглагдаж байна. Үнэндээ бол 1945 оны 8 дугаар сард омнод Сахалин, Курилын аралд болсон хэрэг явдлын эцэст япон vнэнд дийлдэн бууж огсон. Энэ вед ЗХУ товийг сахисан байр суурь баримтлаж байсан нь тvүхэн vнэн. Гэтэл япончууд одоо болохоор тухайн вед СССР итгэл эвдэж тvрэмгийлсэн мэтээр гvтгэх хандлага ихээхэн харагдаж байна. Энэ бол Оросын ард тvмний эсрэг, Монголын ард тvмний эсрэг зvйл богоод аль 70 гаруй жилийн омнох шигээ “солиорол”-д автаж байгаа хэрэг юм. Тиймээс тvүхийн судалгааны хvрээнд, дипломат вйл ажиллагааны хvрээнд энэ асуудлыг анхаарлын товд авах нь чухал хэмээв.

Профессор Д.Цэдэв дэлхийн дайны дараа Гитлерийн эсрэг Европ, Азийн Ялтын бага хуралтай холбогдох асуудлыг хондсон “Агуу их эх орны дайнд немцийн фашизмыг бут ниргэх бvх нийтийн вйл хэрэг ба Монгол улс” гэсэн илтгэлдээ монхvү Баруун Европын болон АНУ-ын судлаачдын зарим судалгааны бvтээлvүдэд тvүхэн баримтыг илт гуйвуулсан, байж боломгvй зvйлvүд байгааг баримтаар няцааж хурц шvүмжилсэн юм.

Монгол улсын Батлан хамгаалах яамны дэргэдэх Цэргийн тvүхийн судалгааны хvрээлэнгийн захирал Сотонгийн Ганболдын “Халхын голын дайны судалгаа орчин вед” гэсэн илтгэлийг Алтайн Бvгд Найрамдах Улсын Сэтгvүлчдийн холбооны нэгдvүгээр орлогч дарга Алексей Сергеевич толилуулсан. Эрдэмтэн С.Ганболд энэ удаад хvрэлцэн ирж чадаагvй ч ирэх наймдугаар сарын 27-нд Монгол улсын Улаанбаатар хотод болох эрдэм

шинжилгээний хуралдаанд заавал оролцоно гэдгээ мэдэгдсэн байна.

Тvнчилэн ихээхэн сонирхолтой илтгэлvвдийн нэгА нь Монгол улсын “Шинэ эвлэл” орон нутгийн сэтгvвчдийн холбооны тэргvн Гонгоржавын Тормонхийн “Халхыг голын байлдаан болон дэлхийн хоёрдугаар дайнд /агуу их эх орны дайн/ оролцож тулалдсан дайчдын мороор” гэдэг илтгэл байв. Г.Тормонх илтгэлдээ 1942-1943 онд Монголын Ховд аймгаас АБНУ-ын Бийск хотод фронтод тусламж хvргэхээр урт замыг туулсан тэмээн жингийн тухай болон Сталинградын дэргэдэх тулалдааны ар талд байж ихээхэн vврэг гvйцэтгэсэн Монгол дайчдын тухай, тэрчлэн Халхын голын байлдаан 1945 оны чолоолох дайнд оролцсон зарим дайчдын тухай урьд олно огт нийтлэгдээгvй ховор баримтуудыг толилуулсан нь анхаарал татаж байв. Тэмээн жингээр Сталинградын дэргэд тулалдаж байсан улаан армийн дайчдад бараг 10.0 мянга орчим нэхий дээл, арьсан бээлий, шинель, 20.0 мянган хос эсгий гутал, эсгий, цоонгvй тонноор хатаасан мах буюу борц хvргэж байсан тухай баримтуудыг vгvвлсэн юм.

Горний Алтайн Улсын их сургуулийн хувьд энэхvв хуралдаан дээр тавигдсан илтгэлvвд нь ихээхэн ач холбогдолтой, дэлхийн хоёр дугаар дайны вeд холбогдох урьд олно илэрхий болоогvй цоонгvй баримт, мэдээллийг гаргаж ирсэн нь vлэмж сонирхолтой юм хэмээн тvвхийн шинжлэх ухааны доктор Николай Модоров хэлсэн юм.А

Горний Алтай хотын нэгдvгээр сургуулийн тvвхийн багш, хичээлийн эрхлэгч Игорь Николаев дайны дараах вeийн хил орчмын харилцаа хамтын ажиллагааны тухай сонирхолтой баримтыг толилуулсан нь тухайн вeд тус сургууль дээр Маршал Х.Чойбалсангийн нэрэмжит музей байгуулж байсан тухай юм.

Басхvв дэлхийн хоёрдугаар дайнд немц хийгээд японы тvрэмгийлэн халдагсдыг бут ниргэхэд Сталин, Жуков, Чойбалсан нар болон цэргийн бусад жанжид, удирдагчдын гvйцэтгэсэн vвргийн тухай сонирхолтой илтгэлийг аспирант Владислав Терентьева ирvвлснийг Алексей Ивашкин илтгэж, толилуулсан.

Дvгнэлтийн хэлэлцvвчдийн вeэр хуралдаанд оролцсон эрдэмтэд, судлаачид нэг зvйл дээр санал нэгтэй шийдэлд хvрсэн нь энэ талаарх хамтын судалгааг vргэлжлvвлэх зайлшгvй шаардлага байна гэдгийг, тэрчлэн тухайн асуудлын хvрээнд тvвхэн внэнийг гуйвуулсан худал хуурмаг мэдээлэл, элдэв суртал ухуулгын эсрэг нотолгоотой няцаалт огох вйлсэд ч хамтран зvтгэхийн чухлыг хуралдааны тогсголийн баримт бичигт албан ёсоор тусгах асуудал байлаа.

Хуралдаанд оролцогсод тэр одрийнхоо орой А.Анохины нэрэмжит vндэсний музейд зочилсон ба Монголын толоологчид 5 сарын 9-ны одор ялалтын баярын албан ёсны арга хэжмээнд толоологчийн хувиар оролцсон юм.

Бэлтгэсэн Дмитрий Соколов

Гэрэл зургийг Любoви ИвашкинойАА